




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 VI



www.1212.mn



Улаанбаатар хот
2024 он

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).


II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000		
сая	=10 ⁶		
тэрбум	=10 ⁹		
их наяд	=10 ¹²		
мян	мянга		
%	хувь		
мм	миллиметр		
см	сантиметр		
дм	дециметр		
м	метр		
км	километр		
м ²	метр квадрат		
дм ²	дециметр квадрат		
км ²	километр квадрат		
м ³	метр куб		
га	гектар		
мл	миллилитр		
л	литр		
г	грамм		
кг	килограмм		
цн	центнер		
т	тонн		
Вт	ватт		
кВт.ц	киловатт цаг		
кал	калори		
ккал	килокалори		
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)		
с	секунд		
мин	минут		
мкг/м ³	микрограмм метр куб		
м/с	метр секунд		
ш	ширхэг		
х.д.х	хэвлэлийн	даралтат	хуудас



ГАРЧИГ



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2023 ОН

1



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР

2



ЭРҮҮЛ МЭНД

3



НИЙГМИЙН ДААТГАЛ

7



ХАЛАМЖ

10



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

12



ГЭМТ ХЭРЭГ

15



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

20



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

24



АЖ ҮЙЛДВЭР

30



МАЛ АЖ АХУЙ

36



ЗАХИРГААНЫ МЭДЭЭ

37

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Шинээр төрсөн хүүхэд		хүн	1 956 ↑5.3	2 041 ↓4.3	1 795 ↓12.1	2 119 ↑18.1	1 942 ↓8.4
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	480 ↓56.3	7 255 ↓15.1дах	24 056 ↑3.3дах	963 ↓96.0	888 ↓7.8
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	587 ↓31.8	712 ↑21.3	1 028 ↑44.3	1 137 ↑15.0	1 191 ↑7.6
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	0.7 ↓0.1	0.7 0.0	0.9 ↑0.2	1.0 ↑0.1	0.7 ↓0.3
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	2 769 ↑5.2	2 850 ↑2.9	2 902 ↑1.8	3 524 ↑21.4	3 391.8 ↓3.3
	Юань (БНХАУ)	төгрөг	395 ↑0.8	438 ↑10.9	457 ↑4.3	511 ↑11.8	472 ↓8.0
	Рубль (ОХУ)	төгрөг	37 ↓7.5	38 ↑2.7	28 ↓26.3	46 ↑64.2	37 ↓19.6
Хан-Уул дүүргийн төсвийн орлого		сая төгрөг	33 028.9 ↑18.0	53 783.9 ↑62.8	67 405.2 ↑25.3	190 736.0 ↑2.8*	256 151.8 ↑187.7
Хан-Уул дүүргийн төсвийн зарлага		сая төгрөг	30 238.7 ↑26.7	21 575.7 ↓8.8	40 894.6 ↑48.3	174228 .6 ↑48.3	247 181.1 ↑206.2
Агаарын дундаж температур		°C	-3.8	6.3	3.1	3.4	0.0

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан



Эерэг хандлага, өөрчлөлт
Сөрөг хандлага, өөрчлөлт

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2023 I-VI					2024 I-VI				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	349	Баянгол	8 579	Налайх	59	349	Баянгол	8 578	Налайх	59
			Чингэлтэй	1 526	Багануур	47		Чингэлтэй	1 526	Багануур	47
			Сүхбаатар	679	Багахангай	32		Сүхбаатар	679	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	14	Сүхбаатар	15	Хан-Уул	8	13	Багахангай	22	Баянзүрх	8
			Сонгинохайрхан	14	Багануур	4		Багануур	19	Сүхбаатар	5
			Баянзүрх	12	Багахангай	-		Баянгол	13	Налайх	3
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	80	Багануур	114	Налайх	44	60	Баянзүрх	65	Багануур	41
			Баянзүрх	91	Сонгинохайрхан	36		Сүхбаатар	52	Сонгинохайрхан	39
			Сүхбаатар	60	Багахангай	23		Баянгол	47	Багахангай	14
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	104	Баянзүрх	184	Чингэлтэй	96	78	Баянзүрх	124	Багахангай	88
			Хан-Уул	121	Налайх	86		Сонгинохайрхан	113	Налайх	87
			Сүхбаатар	120	Багахангай	31		Баянгол	103	Багануур	34
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	139	Чингэлтэй	240	Налайх	75	132	Сүхбаатар	217	Сонгинохайрхан	82
			Сүхбаатар	235	Багануур	50		Чингэлтэй	161	Багануур	58
			Баянгол	145	Багахангай	44		Баянгол	146	Багахангай	41

Тайлбар: * промиль



ЭРҮҮЛ МЭНД, 2024 оны 6 дугаар сар

ᠡᠷᠦᠭᠦᠯᠡᠮᠡᠨᠳᠡ



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2023 **1 300**

2024 **1 048**

80.6%



Амаржсан эх



2023

2543

2024

2281

89.7%



Шинэ төрсөн хүүхэд

2023

2561

2024

2306

90.0%



* Дахин их



ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний 6 сард 1048 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 252 хүнээр (19.4%) буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 48.2 хувийг салхин цэцэг, 13.9 хувийг гар хөл, амны өвчин, 7.3 хувийг цусан суулга, 8.9 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 6.1 хувийг тэмбүү, 3.2 хувийг заг хүйтэн, 0.8 хувийг вируст гепатит, 0.5 хувийг трихомониаз, 11.1 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний VI сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	Өсөлт, бууралт 2024/2023	
					тоо/нэгж	хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	24 599 1 213.4	1 300 58.0	1 048 42.2	-252 -15.8	-19.4
Вируст гепатит	Бодит тоо	7	9	8	-1	-11.1
	10000 хүнд	0.5	0.5	0.3	-0.2	
Цусан суулга	Бодит тоо	44	61	76	15	24.6
	10000 хүнд	2.2	2.7	3.1	0.4	
Улаан эсэргэнэ	Бодит тоо	5	73	46	27	37.0
	10000 хүнд	0.2	3.3	1.9	1.4	
Сальмонеллөз	Бодит тоо	10	9	15	6	66.7
	10000 хүнд	0.5	0.4	0.6	0.2	
Салхин цэцэг	Бодит тоо	115	634	505	-129	-20.3
	10000 хүнд	5.7	28.3	20.3	-8.0	
Гахайн хавдар	Бодит тоо	1	4	20	16	5.0*
	10000 хүнд	0.1	0.2	0.8	0.6	
Ёлом	Бодит тоо	3	3	7	4	2.3*
	10000 хүнд	0.1	0.1	0.3	0.2	
Гар хөл, амны өвчин	Бодит тоо	25	312	146	-166	-53.2
	10000 хүнд	1.2	13.9	5.9	-8.0	
Тэмбүү	Бодит тоо	31	56	64	8	14.3
	10000 хүнд	1.5	2.5	2.6	0.1	
Заг хүйтэн	Бодит тоо	12	26	34	8	30.8
	10000 хүнд	0.6	1.2	1.4	0.2	
Трихомониаз	Бодит тоо	8	4	5	1	25.0
	10000 хүнд	0.4	0.2	0.2	-	
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо	105	94	93	-1	1.1
	10000 хүнд	5.2	4.2	3.7	0.5	
Мөөгөнцөр	Бодит тоо	0	0	0	-	-
	10000 хүнд	0	0	-	-	
Ковид 19	Бодит тоо	24 231	0	1	1	-
	10000 хүнд	1195.3	0	0.0	-	
Бусад өвчлөл	Бодит тоо	2	15	28	13	86.7
	10000 хүнд	0.1	0.6	1.0	0.4	

*дахин

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД



ЗУРАГ 2. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



2024 оны эхний 6 сард эхийн эндэгдэл гараагүй бол нялхсын эндэгдэл 4 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 хүүхдээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний VI сард

Үзүүлэлт	2022 VI	2023 VI	2024 VI	$\frac{2024}{2023}$ %
Амаржсан эхийн тоо	2 205	2 543	2 281	-10.3
Амьд төрсөн хүүхэд	2 219	2 561	2 306	-9.9
Төрөхийн улмаас эндсэн эх	3	1	0	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	21	21	25	19.0
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	5	3	4	33.3

Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс

ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ 2024 оны 6 сард

НИЙГМИЙН ДААТГАЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг




* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

Ажилгүйдлын таатгалын сангаас
тэтгэвэр авагчид

ҮОМШЭ-ний даатгалын сангаас
тэтгэвэр авагчид



Нийт

2 438

2 171

267

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД

Нийт 35 262

Тэтгэвэр авагчдын тоо 27 420

Тэтгэмж авагчдын тоо 9 842



НИЙГМИЙН ДААТГАЛ

2024 оны эхний 6 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 168.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 154.4 тэрбум төгрөгөөр (47.9%) дутуу бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.6 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2024 оны эхний VI сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI
Нийт	242 032.3	322 580.3	265 615.5	168 189.0	109.7	52.1
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	173 783.1	274 355.8	190 998.4	145 405.2	109.9	53.0
Тэтгэмжийн сангийн орлого	16 101.2	23 423.5	16 921.9	11 722.6	105.1	50.0
ҮОМШӨ-ний даатгалын орлого	13 092.3	15 848.2	15 588.5	1 326.8	119.1	8.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	3 380.0	8 951.9	6 431.0	9 733.5	190.3	108.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	35 675.7	0.9	35 675.7	0.9	100.0	100.0


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 86.5 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.0 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 0.8 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 5.8 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 21626 хүнд 113.8 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3257 хүнд 12.1 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1013 хүнд 3.6 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1524 хүнд 12.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 5279 хүнд 2.2 тэрбум төгрөгийг,


жирэмсэн болон амаржсан 2154 хүнд 8.3 тэрбум төгрөгийг, 409 хүнд оршуулгын тэтгэмж 812 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 158 хүнд 875.9 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 16 хүнд 119.1 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 76 хүнд 163.3 сая төгрөгийг тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний сувиллын зардалд 3 хүнд 2.5 сая төгрөгийг, ажилгүйдлийн тэтгэмж авсан 2171 хүнд 8.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 78.9 хувийг тэтгэврийн, 6.5 хувийг тэтгэмжийн, 0.7 хувийг ҮОМШӨ-ний, 4.8 хувийг ажилгүйдлийн, 9.2 хувийг эрүүл мэндийн зардал эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ. **Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2024 оны эхний 6 сард нийгмийн халамжийн сангийн олголтын мэдээгээр нийт 19.4 хувь нь нийгмийн халамжийн сан, 71.6 хувь нь хүүхдийн мөнгө, 1.9 хувь нь алдарт эхийн одон, 2.3 нь насны хишиг, 0.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 3.5 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.2 хувь нь хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, 0.04 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 71.6 хувь нь хүүхдийн мөнгө буюу нийт 98 743 хүнд, 80 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 14 785 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 6. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 оны эхний VI сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	81 078.8	
Улсын төсвийн санхүүжилтийн орлого	81 078.8	
Нийгмийн халамжийн сан	15 764.3	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	412.2	
Алдарт эхийн одонгийн тусламж	1 513.5	
Насны хишиг	1882.0	
Хүүхдийн мөнгө	58 081.8	
Цалинтай ээж хөтөлбөр	2 825.4	
Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж	36.2	
Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	410.4	
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	19.2	
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	133.9	
Зарлагын нийт дүн	81 078.8	160513
Нийгмийн халамжийн сан	15764.3	19 950
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3 648.0	14 785
Алдарт эхийн одонгийн тусламж	1 513.5	12 793
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	36.2	80
Хүүхдийн мөнгө	58 081.8	98 743
Насны хишиг	1882.0	12 200
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	19.2	16
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	133.9	1 946

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



ЦАГ УУР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ (2024 оны 06 дугаар сард)

ᠴᠠᠭ ᠤᠭᠤᠷ,
ᠠᠶᠤᠭᠤᠯᠤᠲᠤ ᠤᠵᠡᠭᠦᠳᠡᠯ,
ᠣᠰᠣᠯ

Агаарын температур °C (Үнэмлэхгүй их/ бага)



31.2°C

Хамгийн дулаан хэм



0.3°C

Хамгийн хүйтэн хэм

Гал түймрийн тоо



2024 I-VI 899 1.6% ↓

2023 I-VI 914

Хүний үйл ажиллагаатай холбоотой осол



1

Үйлдвэрийн осол



18

Усны осол



120

Бусад

Байгаль орчны зөрчил



357

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2024 оны 6 дугаар сард дунджаар 16.1 °С байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.2 °С-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 1.2 °С-аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 31.2°С, хамгийн хүйтэн хэм 0.3 °С, хур тунадасны нийлбэр 106.9 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 21 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 7. АГААРЫН БОХИРДОЛТ, мг/м³, VI сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	270	0.036	-	0.039
Азотын давхар исэл	NO ₂	0.050	322	0.175	30	0.031
Тоосжилт	PM ₁₀	0.100	358	0.263	21	0.051
	PM _{2.5}	0.050	265	0.046	-	0.012
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	984	3.414	-	0.357
Озон	O ₃	0.100	703	0.166	129	0.057

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 оны 06 дугаар сард Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.039 мг/м³ (2.4 дахин), озоны дундаж агууламж 0.057(21.0%)- иар, азотын давхар ислийн дундаж агууламж 0.031 мг/м3 (10.7%)-иар тус тус өндөр байхад, нүүрстөрөгчийн дутуу ислийн дундаж агууламж 0.357 мг/м3 (33.0%)-иар бага байна.

ХҮСНЭГТ 8. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО,станц, 2024 оны VI сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоосонцор (PM ₁₀)	Тоосонцор (PM _{2.5})
Нийт	-	30	-	19	0
Мишээл экспо	-	-	-	-	-
Баруун 4 зам	-	30	-	1	-
Тахилт	-	-	-	1	-
13-р хороолол	-	-	-	3	-
Зуун айл	-	-	-	12	-
Цахилгаан станц	-	-	-	-	-
Ургах наран хороолол	-	-	-	1	-
Таван буудал	-	-	-	-	-
Богд хааны ордон музей	-	-	-	-	-
Нисэх	-	-	-	-	-
Толгойт	-	-	-	-	-
Зурагт	-	-	-	-	-
Амгалан	-	-	-	2	-
Баянхошуу	-	-	-	-	-

¹ 8 цагийн дундаж
Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2024 оны эхний хагас жилд 300 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өссөн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой бусад төрлийн 120 осол, усны осол 18, үйлдвэрийн осол 1 бүртгэгджээ. Гамшгийн улмаас 31 хүн амь насаа алдаж, 559 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 20.4 сая төгрөг зарцуулжээ.

ХҮСНЭГТ 9. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, дүүргээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Дүүрэг	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2024/2023
							Хувь
Нийслэлийн дүн	1 258	864	617	1 111	914	899	98.3
Багануур	16	13	11	17	13	16	123.1
Багахангай	5	3	-	3	2	6	300.0
Баянгол	146	101	68	107	101	88	87.1
Баянзүрх	306	194	150	295	216	240	111.1
Налайх	26	23	18	29	29	38	131.0
Сонгинохайрхан	327	231	149	296	228	207	90.8
Сүхбаатар	168	120	81	136	136	103	75.7
Хан-Уул	115	83	67	128	95	111	116.8
Чингэлтэй	149	96	73	100	94	90	95.7

Нийслэл хотод 2024 оны эхний хагас жилд ахуйн 899 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурсан байна . Гал түймрийн улмаас 23 хүн амь насаа алдаж, 30 хүн түлэгдэж гэмтсэн байна. Худал дуудлагын тоо 11 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна.

Гал түймрийн аюулаас 2277 хүн, 326 байшин барилга, 148.2 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 309, санамсаргүй

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ГЭМТ ХЭРЭГ,
2024 оны эхний 6 сард

Сүхбаатар
Сонгинохайрхан




Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2023 I-VI
1835

2024 I-VI
2302 25.4% ↑

Дүүргээр



↓ ↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн
2241



Гэмтсэн хүн
356



Нас барсан хүн
49



ГЭМТ ХЭРЭГ

2024 оны 6-р сарын байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт 2302 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 467 хэргээр (25.4 хувиар) өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр


Төрөл	2023 I-VI	2024 I-VI	Үүнээс: Цагдаагийн хэлтсээр		Өсөлт, бууралт	
			I	II	Тоо	Хувь
Нийт	1 835	2 302	1 424	878	467	25.4
Үүнээс:						
Илрээгүй хэрэг	1 113	1 624	949	678	511	45.9
Хэрэг бүртгэлийн хэрэг	1 810	2 221	1 358	863	401	22.7
Ял сонссон хэрэг	697	597	412	185	- 100	85.7

ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, Эхний VI сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2024/2023	
	2022 I-VI	2023 I-VI	2022 I-VI	2023 I-VI	2022 I-VI
Дүүргийн дүн	1 444	1 835	2 302	467	25.4
Хүнийг алах /10.1/	11	9	8	- 1	88.9
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	6	14	32	18	28.6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	302	298	324	26	8.7
Хүчиндэх /12.1/	19	18	20	2	11.1
Хулгайлах /17.1/	316	273	515	242	88.6
Дээрэмдэх /17.2/	16	9	23	14	55.5
Залилах /17.3/	525	836	874	38	4.5
Малын хулгай	4	7	-	7	-
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах /20.16/	-	-	3	3	-
ХАБТХАЖЭ* /27.1-27.11/	45	48	67	19	39.6
Бусад	200	323	436	113	35.0

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 14.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бол 38.0 хувийг залилах, 22.4 хувийг хулгайлах, 2.9 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, 1.0 хувийг хүчиндэх, 1.0 хувийг дээрэм, 0.3 хувийг хүнийг алах, 1.4 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 18.9 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2022-2024	
	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	13 807	13 551	14 162	611	104.5
Хан-уул	1 443	1 835	2 302	467	125.4
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр					
I хэлтэс	825	1 189	1 424	235	119.8
II хэлтэс	618	646	878	232	135.9
Нийслэлийн дүнд эзлэх хувь	10.5	13.6	16.3	2.7	19.9

Дүүргийн хэмжээнд 2024 оны 6-р сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувь 16.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр өссөн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 61.9 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 13. ЗӨРЧИЛ-ийн мэдээ, хэлтсээр

Хэлтэс	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг		Эмэгтэй хүн оролцсон		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI
Цагдаагийн I	70	82	132	143	20	37
Цагдаагийн II	61	68	54	77	10	25
ХУД Цагдаагийн газар	131	150	186	220	30	62

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2024 оны 6-р сард 62 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн бол өмнөх онтой харьцуулахад 32 (51.6%)-иар өссөн, дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 2241 иргэн хохирсны 1061 (47.3%) нь эмэгтэйчүүд байсан бол 10 (0.4%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 59 (2.6%) нь 8-13 насны хүүхэд, 133 (5.9%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 356 хүн гэмтэж осолдон, 49 хүн нас барж, төр ард иргэдэд 70117.5 сая төгрөгийн хохирол учруулсны 26446.4 (37.7%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2024 оны 6-р сарын байдлаар тус дүүргийн 15 дугаар хороонд 287 гэмт хэрэг гарч хамгийн өндөр байхад 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 13 хэрэг гарсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.


ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

Хороод	Нийт дүн	Хүнийг алах /10.1/	Хүнийг амиа хорлох нөхцөлд байдалд хүргэх /10.4/	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	Хүчиндэх /12.1/	Хулгайл ах /17.1/	Үүнээс			Дээрэмдэх /17.2/	Залилан мэхлэх /17.3/	Олон нийтийн амгалан тайван байдал /20.1-20.17/	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг /27.1-27.11/	Бусад
							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай					
1-р хороо	111	-	1	10	1	23	14	-	9	1	42	-	2	31
2-р хороо	104	3	-	18	-	19	15	-	4	2	43	-	2	17
3-р хороо	185	-	1	29	4	28	23	-	5	2	75	-	11	35
4-р хороо	111	-	1	13	2	29	24	-	5	1	35	-	1	29
5-р хороо	23	1	-	1	-	7	4	-	3	1	6	-	2	5
6-р хороо	31	-	1	6	1	8	7	-	1	1	8	-	1	5
7-р хороо	13	-	-	2	1	6	4	-	2	-	2	-	-	2
8-р хороо	76	-	-	9	1	19	16	1	2	1	20	-	6	20
9-р хороо	40	-	-	14	2	9	9	-	-	-	10	-	2	3
10-р хороо	65	-	4	10	1	11	11	-	-	1	25	-	6	7
11-р хороо	157	-	-	28	-	32	25	1	6	1	59	2	3	32
12-р хороо	34	-	3	5	-	13	13	-	-	-	6	-	2	5
13-р хороо	24	1	3	6	-	5	4	-	1	-	2	-	3	4
14-р хороо	51	2	1	10	1	14	13	1	-	-	11	-	4	8
15-р хороо	287	-	2	47	1	75	60	-	15	5	93	1	8	55
16-р хороо	63	-	2	10	-	20	18	1	1	1	15	-	4	11
17-р хороо	82	1	-	10	-	19	19	-	-	1	38	-	1	12
18-р хороо	121	-	2	11	-	32	27	-	5	1	53	-	-	22
19-р хороо	62	-	-	13	1	16	15	-	1	-	22	-	1	9
20-р хороо	281	-	1	32	-	19	17	-	2	1	172	-	2	54
21-р хороо	102	-	4	6	2	27	25	-	2	2	41	-	1	19
22-р хороо	34	-	2	4	-	13	13	-	-	-	10	-	1	4
23-р хороо	77	-	2	11	1	17	17	-	-	1	27	-	2	16
24-р хороо	106	-	2	14	1	34	24	-	10	-	36	-	1	18
25-р хороо	62	-	-	5	-	20	18	-	2	-	23	-	1	13
Нийт дүн	2 302	8	32	324	20	515	435	4	76	23	874	3	67	436



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 оны 6 дугаар сард, тэрбум төгрөг

Баян



Хан-Уул дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц






ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2024 оны эхний 6 дугаар сарын байдлаар 418.3 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 63.7 тэрбум төгрөгөөр (13.2%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2023 оноос 39.0 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 48.3 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 51.7 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 10. ТӨСВИЙН ОРЛОГО, сая төг



Татварын орлогын хэмжээ 202.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 36.4 тэрбум төгрөгөөр (15.3%), татварын бус орлого 216.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 27.3 тэрбум төгрөгөөр (11.2%) тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 оны эхний VI сард, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	482 053.0	418 352.1	86.8	-63 700.9
1.Татварын орлогын дүн	238 487.4	202 073.9	84.8	-36 413.5
1.1 Орлогын албан татвар	185 839.8	168 756.3	90.8	-17 083.5
Хувь хүний орлогын албан татвар	185 839.8	168 756.3	90.8	-17 083.5
1.2 Хөрөнгийн албан татвар	12 698.2	11 427.8	90.0	-1 270.4
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	39 949.4	21 889.8	54.8	-18 059.7
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	21 727.1	6 548.0	30.1	-15 179.1
Улсын тэмдэгтийн хураамж	20 196.0	5 257.6	26.0	-14 938.4
Ашигт малтмал ашигласны төлбөр	80.8	75.7	93.8	-5.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 450.4	1 214.6	83.7	-235.7
1.3.2 Газрын төлбөр	18 202.4	15 310.7	84.1	-2 891.7
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	19.9	31.1	156.0	11.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	19.9	31.1	156.0	11.2
2.Татварын бус орлогын дүн	243 565.6	216 278.2	88.8	-27 287.4
2.1 Нийтлэг бус татварын орлого	1 791.9	2 620.0	146.2	828.0
Торгуулийн орлого	1 485.0	2 399.8	161.6	914.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	286.5	198.5	69.3	-88.1
Бусад орлого	20.4	21.7	106.3	1.3
2.2 Тусламжийн орлого	240 370.5	212 263.6	0.2	0.2
2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв	1 403.2	1 394.6	99.4	-8.6
хоорондын шилжүүлэг				

Тайлбар: Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

ХҮСНЭГТ 16. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 оны эхний VI сард, сая.төг


Төсвийн орлого			Үүнээс:						
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	418 352.1	86.8	-63 700.9	202 073.9	84.7	-36 413.5	216 278.2	88.8	-27 287.4

Орлогын албан татвар төлөвлөснөөс 17.1 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 1.3 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 18.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

2024 оны эхний 6 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 448.5 тэрбум төгрөгийн (86.1%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 72.2 тэрбум төгрөгийг (13.9%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 1.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 98.5 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

ЗУРАГ 11. ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төг




ХҮСНЭГТ 17. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 оны эхний VI сард, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	418 352.1	520 708.6	448 467.0	86.1	-72 241.5	-30 114.7

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 47.5 сая төгрөгийн үлдэгдэл байсан бөгөөд 1.0 сая төгрөгөөр шинээр өглөг үүсэж, 41.3 сая төгрөг төлөгдөж сарын сүүлээр 7.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ХҮСНЭГТ 18. ӨГЛӨГ, 2024 оны эхний VI сард, сая.төг

	6-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	6-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	47.5	1.0	41.3	7.2

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2024 оны 6 дугаар сард)

Хэрэглээний үнийн индекс

Ерөнхий индекс

4.8

Хүнсний бараа, согтууруулах
бус ундаа

3.9

Согтууруулах ундаа, тамхи,
мансууруулах бодис

4.2

Хувцас, бөс бараа, гутал

4.1

Орон сууц, ус, цахилгаан,
хийн болон бусад түлш

5.6

Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа

5.9

Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ

7.3

Тээвэр

-1.3

Холбооны хэрэгсэл,
шуудангийн үйлчилгээ

1.8

Амралт, чөлөөт цаг,
соёлын бараа, үйлчилгээ

3.9

Боловсролын үйлчилгээ

21.2

Зочид буудал, нийтийн хоол,
дотуур байрны үйлчилгээ

8.8

Даатгал, Санхүүгийн үйлчилгээ

2.3

Бусад бараа, үйлчилгээ

11.6

-5 0 5 10 15 20 25




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өслөө.

2024 оны 06 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 3.7 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 13. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



ХҮСНЭГТ 19. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2023-V</u> 2022-V	<u>2024-VI</u> 2023-VI	<u>2024-VI</u> 2023-XII	<u>2024-VI</u> 2024-V
Ерөнхий индекс	110.4	104.8	103.7	100.4
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	116.8	103.9	110.1	100.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	107.5	104.2	101.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	114.1	104.1	101.5	100.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	107.5	105.6	102.1	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	110.1	105.9	104.3	100.7
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	105.9	107.3	103.0	100.2
Тээвэр	101.0	98.7	98.2	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	102.3	101.8	102.4	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	106.3	103.9	101.8	100.0
Боловсролын үйлчилгээ	110.7	121.2	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	115.9	108.8	104.2	101.0
Даатгал, Санхүүгийн үйлчилгээ	102.9	102.3	102.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	125.8	111.1	102.1	100.7

2024 оны 06 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 404 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 18.8 хувь нь өсөж, 11.8 хувь нь буурч, 69.4 хувь нь тогтвортой байв.

ХҮСНЭГТ 20 . УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**эерэг, сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт хувь	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	1.8	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Мах, махан бүтээгдэхүүний үнэ 0.2 хувиар, Загас, далайн бүтээгдэхүүн 5.3 хувиар, Хүнсний ногооны үнэ 8.0 хувиар, Сахар, жимсний чанамлын үнэ 1.6 хувиар, Ундааны үнэ 0.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Согтууруулах ундаа, Тамхи, мансууруулах бодис	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Орон сууцны урсгал засварын бараа материалын үнэ 0.4 хувиар өссөн нь нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.8 хувиар, Гэр ахуйн жижиг цахилгаан хэрэгслийн үнэ 0.1 хувиар, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулгын үнэ 1.6 хувиар, Гэр ахуйн бараа 1.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв
Орон сууц, Ус, Цахилгаан, Хийн болон бусад түлш	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм, тариа 0.4 хувиар, Эрүүл мэндийн бусад бараа 2.5 хувиар өссөн нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үнэ 6.0 хувиар өссөн нь нөлөөлөв.
Бусад бараа үйлчилгээ	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Ресторан, кафе, бусад зоогийн газрын үйлчилгээний үнэ 1.5 хувиар өссөн нь нөлөөлөв.


2024 оны 6 дугаар сарын 15 -ний өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ 300 төгрөг, ‘, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 550 төгрөг “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 310 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 330 төгрөг, элсэн чихэр 300 төгрөг, төмс 300 төгрөг, лууван 300 төгрөг, сонгино 140 , цагаан будаа 1800 төгрөг, задгай сүү 1000 төгрөгөөр тус тус өссөн. Хонины ястай мах 800 , ‘Үхрийн мах” ястай 2500 төгрөг байцаа 200 төгрөгөөр буурсан. Харин манжин , Польш алим, Тараг,цөцгийтэй,”СҮҮ “ ХК, үнэ тогтвортой байлаа.

ХҮСНЭГТ 21. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн VI сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2023.VI	2024.VI	$\frac{2024}{2023}\%$
Талх "Атар", "Талх чихэр" ХК	Ширхэг	2 100	2 400	114.3
Хонины мах, ястай	Кг	15 800	15 000	94.9
Үхрийн мах, ястай	Кг	19 500	17 000	87.2
Гурил , дээд зэрэг, "Алтан тариа" ХК,	Кг	2 690	3 240	120.4
Гурил ,1-р зэрэг, "Алтан тариа" ХК,	Кг	2 330	2 640	113.3
Гурил, 2-р зэрэг, "Алтан тариа" ХК,	Кг	1 500	1 830	122.0
Элсэн чихэр	Кг	4 200	4 500	107.1
Төмс, монгол	Кг	2 500	2 800	112.0
Байцай, монгол	Кг	2 700	2 500	92.6
Лууван, монгол	Кг	2 500	2 800	112.0
Манжин, монгол	Кг	6 500	6 500	100.0
Сонгино, хятад	Кг	3 360	3 500	104.2
Цагаан будаа	Кг	4 300	6 100	141.9
Алим, Польш	Кг	8 000	8 000	100.0
Сүү, задгай	литр	3 000	4 000	133.3
Тараг, цөцгийтэй, "Сүү " ХК	литр	4 140	4 140	100.0

Тайлбар: Худалдаа үйлчилгээний "Мөнхсувраг" төв



ЗУРАГ 14. НЭГ КГ ХОНИНЫ МАХНЫ дундаж үнэ, төгрөг




ЗУРАГ 15. НЭГ КГ ҮХРИЙН МАНХНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 16. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VI сард, төгрөг





ЗУРАГ 17 . НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VI сард, төгрөг



ХҮСНЭГТ 22. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2023.VI.19					2024.VI.19				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Петровис	3 710	2 370	2 390	3 450	-	3 910	-	2 390	3 390	-
Магнай трейд	3 710	-	2 390	3 480	-	3 910	-	2 390	3 390	-
Сод монгол	3 710	2 320	2 390	3 450	-	3 910	-	2 390	3 390	-
Шунхлай	3 710	2 350	2 390	3 450	-	3 910	-	2 390	3 390	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	3 710	2 345	2 390	3 450	1 790	3 910	-	2 390	3590	1 790

Тайлбар: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 6-р сарын мэдээ

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
 t – Тайлант үе
 0 – суурь үе
 P_{it}^i – i барааны тайлант үеийн үнэ
 P_{i0}^i – i барааны тайлант үеийн үнэ
 Q_{i0}^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны 6 дугаар сард


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг





АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2024 оны эхний 6 сард 909.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 992.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 133.5 хувиар, борлуулалт 98.6 хувиар буурсан байна.

ЗУРАГ 18. АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



Боловсруулах аж үйлдвэрийн салбарт цагаан архи өмнөх оны мөн үеэс 2 дахин өсөж, бусад гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2.5-31.2 хувиар буурсан байна. Харин самнасан ноолуур 24.5 хувиар буурсан бол дулаан эрчим хүчний үйлдвэрлэл 75.5 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 23-. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 I-VI*	2024 I-VI	2024 I-VI / 2023* I-VI
Боловсруулах аж үйлдвэр				
Малын мах	тн	175.0	82.5	47.1
Өлөн гэдэс	мян.гогцоо	13.3	22.5	169.2
Боловсруулсан шингэн сүү	мян.л	15 305.6	13 878.0	90.7
Талх	тн	2 748.1	1 737.9	63.2
Нарийн боов	тн	1 955.8	1 825.8	93.4
Цагаан архи	мян.л	6 524.0	14 929.8	228.8
Соёолжоор бэлтгэсэн шар айраг	мян.л	32 203.6	31 404.9	97.5
Самнасан ноолуур	тн	172.4	130.2	75.5
Хивс, шалны нэхмэл дэвсгэр	мян.м2	25.0	28.1	112.4
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	59.2	40.7	68.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж				
Цахилгаан эрчим хүч	мян.квт.цаг	510 396.7	497 792.1	97.5
Дулааны эрчим хүч	мян.гкал	1 838.0	257.5	14.0

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 4507.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3758.1 (6 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 909.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 228.2 (33.5%) тэрбум төгрөгөөр өсөхөд жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт 424.4 (11.7) тэрбум

төгрөгөөр, хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа -1775.2 (15.1%) тэрбум төгрөгөөр, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл -2324.1 (50.6%) тэрбум төгрөгөөр арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.3 (23.1%) тэрбум төгрөгөөр, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 30.1 (68.5%) тэрбум төгрөгөөр тус тус голлох нөлөө өссөн байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 86.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 (5.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 8.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5039.5 (2 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2024 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 909.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 0.5 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 89.1 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 9.5 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.9 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 24. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөгөөр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2023 I-VI*	2024 I-VI	<u>2024</u> 2023
	сая төгрөг		
БҮГД	681 590.7	909 807.8	133.5
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	749.8	4 507.9	6*
Бусад ашигт малтмал олборлолт	749.8	4 507.9	6*
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	595 144.0	810 265.6	136.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	308 333.1	500 537.8	162.3
Мах боловсруулах, консервлох	2 680.6	2 302.2	85.9
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	3 620.1	4 044.5	111.7
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	72 334.0	75 627.4	104.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	29 319.1	26 710.7	91.1
Малын тэжээл үйлдвэрлэл	2 853.9	6 007.8	210.5
Ундаа үйлдвэрлэл	197 525.4	385 845.2	195.3
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	64 342.2	47 189.3	73.3
Хувцас үйлдвэрлэл	97 509.4	95 617.4	98.1
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 916.2	12 205.3	123.1
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16 785.0	16 312.6	97.2
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	11 729.7	9 954.5	84.9
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	43 942.9	74 065.1	168.5
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	14 625.1	20 607.9	140.9
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 593.9	2 269.8	49.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	9 021.4	9 001.0	99.8
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	898.9	5 939.4	660.7
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.6	-	-
Тавилга үйлдвэрлэл	3 295.3	2 206.1	66.9
Бусад боловсруулах үйлдвэрлэл	8 669.1	10 874.3	125.4
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	1 460.2	3 485.1	238.7
ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	82 029.0	86 326.8	105.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	82 029.0	86 326.8	105.2
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	3 667.9	8 707.5	237.4
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	3 667.9	8 707.5	237.4

*дахин их

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 992.9 тэрбум төгрөгийг дотоодод, 53.9 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 40.7 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 63.9 хувийг ээрэх нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл, 0.1 хувийг нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл, 5.2 хувийг ундаа үйлдвэрлэл, 0.3 хувийг мах боловсруулах үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 25. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар, оны

үнээр, сая төгрөгөөр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2023 I-VI*	2024 I-VI	2024 2023	Үүнээс: Экспорт (хувиар)
	сая төгрөг			
БҮГД	1 007 131.0	992 946.9	98.6	40.7
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	749.7	4 507.9	6*	
Бусад ашигт малтмал олборлолт	749.7	4 507.9	6*	
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	919 501.8	894 371.8	97.3	6.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	641 167.2	595 524.3	92.9	
Мах боловсруулах, консервлох	3 552.7	5 367.1	151.1	0.3
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	3 517.0	3 721.7	105.8	
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	111 929.7	114 080.9	101.9	
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	29 277.9	48 551.4	165.8	
Малын тэжээл үйлдвэрлэл	2 854.0	6 007.8	210.5	
Ундаа үйлдвэрлэл	490 035.9	417 795.4	85.3	5.2
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	65 635.5	50 057.2	76.3	63.9
Хувцас үйлдвэрлэл	81 770.6	77 426.8	94.7	0.1
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 655.3	14 493.7	136.0	
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16 940.4	16 232.3	95.8	
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	14 668.9	12 395.5	84.5	
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	43 936.7	74 517.1	169.6	
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	16 382.9	19 836.3	121.1	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 689.4	2 536.8	54.1	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	9 340.8	8 760.5	93.8	
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	623.7	5 945.1	9*	
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.5	-	-	
Тавилга үйлдвэрлэл	3 298.6	2 401.2	72.8	
Бусад боловсруулах үйлдвэрлэл	8 885.7	10 759.9	121.1	
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	1 484.6	3 485.1	234.8	
ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	82 029.0	84 326.8	102.8	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	82 029.0	84 326.8	102.8	
УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	4 850.5	9 740.4	200.8	
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	4 850.5	9 740.4	200.8	

*дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.



МАЛ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний 6 сард 8441 хээлтэгч мал төллөжээ. Нийт гарсан төлөөс 338 (4.0%) нь хорогдож, 8103 (96.0%) төл бойжиж байна. Бойжуулсан нийт төлийн 16.7 хувийг унага, 31.9 хувийг тугал, 26.9 хувийг хурга, 24.5 хувийг ишиг эзэлж байна.

ХҮСНЭГТ 26. ТОМ МАЛ-ын зүй бус хорогдол, дүүргээр, VI сард


Үзүүлэлт	2023 I-VI	2024 I-VI	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	13 304	8 441	-	1 387	2 668	2 298	2 088
Гарсан төл	13 304	8 441	-	1 387	2 668	2 298	2 088
Үүнээс: Хорогдсон төл	508	338	-	32	83	122	101
Бойжсон төл	12 796	8 103	-	1 355	2 585	2 176	1 987

2024 оны эхний 6 сард 4156 толгой том мал зүй бусаар хорогдож том малын зүй бус хорогдлын 1779 (42.9%) нь хээлтэгч мал байна. Хорогдсон нийт малын 15.6 хувийг адуу, 11.8 хувийг үхэр, 38.3 хувийг хонь, 34.3 хувийг ямаа эзэлжээ.

ХҮСНЭГТ 27. ТОМ МАЛ-ын зүй бус хорогдол, дүүргээр, VI сард

Төрөл	2022		2023		2024	
	Хорогдсон мал	хээлтэгч	Хорогдсон мал	хээлтэгч	Хорогдсон мал	хээлтэгч
Дүүргийн дүн	235	61	1 385	279	4 156	1 781
12-р хороо	11	3	209	12	235	16
13-р хороо	75	33	523	124	1 023	532
14-р хороо	149	25	653	143	2 898	1 233

ЗУРАГ 19. ТОМ МАЛ-ын зүй бус хорогдлын мэдээ, сараар



Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй) зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2024 оны эхний 6 сард Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 2244 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 2137 өргөдөл өгч, хугацаа болоогүй гомдолд хариу 105, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн 2 өргөдөл байна.

ХҮСНЭГТ 28. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл			
Удирдлага	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТЗУХ	34	-	2	31	1	6	25	2	1	-	29	5	-
СТСХ	10	-	2	8		2	7	-	1	-	10	-	-
ТГУХ	24	-	7	15	2	15	5	-	4	-	20	4	-
НБХ	16	-	10	6		10	3	2	1	-	15	1	-
ТНБХХУХ	266	-	32	221	13	100	153	1	12	-	250	16	-
ХХҮХ	160	-	7	152	1	35	117	-	8		150	10	-
ХЭЗАХ	20	-	12	6	2	13	6	-	1	-	17	3	-
Цэргийн штаб	53	-	53	-	-	53	-	-	-	-	53	-	-
ЗДТГ-ын дүн	583	0	125	439	19	234	316	5	28	0	544	39	-
Албан бус- НТБ төв	2	-	2	-	-	2	-	-	-	-	2	-	-
Биеийн тамир, спортын хороо	1	-	-	1	-	1	-	-	-	-	1	-	-
Боловсролын хэлтэс	84	-	10	73	1	11	58	12	3	-	84	-	-
Газрын алба	581	-	410	162	9	461	115	-	5	-	565	15	1
ГБХЗХХ	47	-	45	2	-	37	3	1	6	-	43	4	-
НДХ	148	-	27	121	-	35	107	5	1	-	137	11	-
Онцгой байдлын хэлтэс	14	-	-	11	3	9	5	-	-	-	13	1	-
Татварын хэлтэс	353	-	341	11	1	338	13	1	1	-	331	21	1
Цагдаагийн газар	171	-	-	168	3	10	106	53	-	-	166	5	-
ХөХҮХ	206	-	147	59		141	59	4	2	-	197	9	-
УБХ	44	-	7	36	1	14	23	3	4	-	44	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	9	-	9	-	-	9	-	-	-	-	9	-	-
Соёлын ордон	1	-	1	-	-	1	-	-	-	-	1	-	-
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	1 661	0	998	645	18	1 069	490	79	23	0	1 593	66	2
Нийт дүн	2 244	0	1 123	1 084	37	1 303	806	84	51	0	2 137	105	2

Танилцуулгыг хянасан:

О.Гэрэл

Ё.Ганчимэг

Танилцуулгыг бэлтгэсэн:

Ц.Энх-Оюун



Газар тариалан, хөдөө аж ахуй, эрүүл мэнд

Ж.Энх-Амгалан



Хан-Уул дүүргийн төсөв, барилга, нийгмийн даатгал

Ё.Ганчимэг



Аж үйлдвэр, гэмт хэрэг,
инфографик мэдээлэл, хавтасны дизайн

Н.Болор-Эрдэнэ



Хэрэглээний үнэ, нийгмийн халамж

Танилцуулгыг нэгтгэсэн:

Ё.Ганчимэг

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС